

“ЗҮҮН АЗИ ДАХЬ ХЭЛ СОЁЛЫН ХАРИЛЦАА”

*(хятад, монгол, манж, солонгос хэлээр туурвисан ‘lao qida’-д
тулгуурласан цогц судалгаа)*

СЭДЭВТ СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Төслийн дугаар:	Шу Сс-2018/41
Төслийн удирдагч:	Т.Отгонтуул /хэл бичгийн ухааны доктор, профессор/
Төслийн зөвлөх:	Л.Маналжав /хэл бичгийн ухааны доктор, профессор/
Төслийн гүйцэтгэгчид:	М.Баярсайхан /хэл бичгийн ухааны доктор, профессор/ Э.Жаргалмаа /МУИС, докторант/ Квон СонХүн /МУИС-ийн багш, докторант/ Жү Сүхён /МУИС, докторант/
Санхүүжүүлэгч байгууллага:	Шинжлэх Ухаан Технологийн Сан
Захиалагч байгууллага:	Боловсрол Шинжлэх ухааны Яам
Гүйцэтгэгч байгууллага:	Монгол Улсын Их Сургууль, ЭШИ. Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим. Хаяг: Их сургуулийн гудамж-1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, МУИС, 2-р байр, 305 тоот.

Улаанбаатар хот
2022



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



“ЗҮҮН АЗИ ДАХЬ ХЭЛ СОЁЛЫН ХАРИЛЦАА”

*(хятад, монгол, манж, солонгос хэлээр туурвисан ‘lao qida’-д
тулгуурласан цогц судалгаа)*

СЭДЭВТ СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Төслийн дугаар:	Шу Сс-2018/41
Төслийн удирдагч:	Т.Отгонтуул /хэл бичгийн ухааны доктор, профессор/
Төслийн зөвлөх:	Л.Маналжав /хэл бичгийн ухааны доктор, профессор/
Төслийн гүйцэтгэгчид:	М.Баярсайхан /хэл бичгийн ухааны доктор, профессор/ Э.Жаргалмаа /МУИС, докторант/ Квон СонХүнь /МУИС-ийн багш, докторант/ Жү Сүхён /МУИС, докторант/
Санхүүжүүлэгч байгууллага:	Шинжлэх Ухаан Технологийн Сан
Захиалагч байгууллага:	Боловсрол Шинжлэх ухааны Яам
Гүйцэтгэгч байгууллага:	Монгол Улсын Их Сургууль, ЭШИ. Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим. Хаяг: Их сургуулийн гудамж-1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, МУИС, 2-р байр, 305 тоот.

АГУУЛГА

Удиртгал	3
Төслийн үндэслэл, шаардлага	3
Төслийн ач холбогдол.....	4
Төслийн судалгааны эх хэрэглэгдэхүүн, судлагдсан байдал.....	5
Төслийн бүрэлдэхүүн.....	6
ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР 1. (2018 ОН)	
Олон улсын эрдэм шинжилгээний хурал.....	8
Хурлын эмхэтгэл.....	8
Төслийн судлаачдын хэлэлцүүлсэн илтгэл.....	12
ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР 2. (2019 ОН)	40
Манж нугэлдэйн судалгаа 1.....	40
Монгол нугэлдэйн судалгаа 1.....	42
Хятад нугэлдэйн судалгаа 1.....	44
Эрдэм шинжилгээний семинар, хэлэлцүүлэг 1.....	48
Эрдэм шинжилгээний өгүүлэл.....	50
ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР 3. (2022 ОН)	61
Манж нугэлдэйн судалгаа 2.....	61
Монгол нугэлдэйн судалгаа 2.....	63
Хятад нугэлдэйн судалгаа 2.....	65
Эрдэм шинжилгээний семинар, хэлэлцүүлэг 2.....	65
ДҮГНЭЛТ.....	68

Удиртгал

Монголын эзэнт гүрний хүрээнд Монголын Юань улс, Ил хаадын улс, Чагадайн улс багтаж, энэхүү өргөн уудам нутагт олон үндэстэн, соёл, хэл хавьсан учирч байсныг түүх өгүүлдэг. Ийм нөхцөл байдал Европ тивийн түүхэнд гарч, эртний грек, латин, славян хэлнүүдэд хэрхэн нөлөөлж байсныг барууны үе үеийн хэл шинжлэлчид, ялангуяа түүхэн харьцуулах аргыг үндэслэн нягтлан судлаж ирсэн билээ. Харин Монголын Эзэнт Гүрэн байгуулагдсанаас хойш Евро Азийн энэхүү уудам нутагт хэл, соёлын байдалд ямар өөрчлөлт гарсан, монголчууд бусад үндэстэн ард түмний бичиг соёлд хэрхэн нөлөөлж чадсан тухайд тусгайлсан судалсан зүйл өнөө хэр ховор байна.

Олон хэл соёлтой хүмүүс уулзан учрах нөхцөл XIII-XIV зууны үеэс Зүүн Ази, тодруулбал Зүүн хойд Азид бий болсон. Монголын Юань гүрний үед олон хэл, соёлтой хүмүүс уулзан золгосон явдал тэдний хэл соёлд тусгалаа олсон бөгөөд эдгээр соёл нь хятад, энэтхэг, төвд, араб-перс болон Төв Азийн соёл байлаа. Чухам энэ үед Монголын Хубилай хааны санаачлан хийсэн шинэчлэлүүдийн нэг бол шинэ бичиг болох дөрвөлжин үсгийг зохиолгосон явдал байв. Ийнхүү олон хэл, соёлтой хүмүүс уулзан учрах нь түүхийн тодорхой нөхцөлд өөр өөр хэл бие биений нөлөөнд орж, тухайн хэлэнд нөлөөлдөг хэлний хөгжил өөрчлөлтөд нөлөөлөгч гадаад хүчин зүйлийн нэг бол хэлний харилцан нөлөөлөл юм. Түүхийн тодорхой үе шатанд Зүүн Азийн хэд хэдэн хэлээр бүтээсэн (*хятад хэлээрх анхны эх нь 1346 онд зохиогдсон*) “Нүгөлдэй(Lao qida)” хэмээх номын цогц судалгаагаар дамжуулан солонгос, монгол, манж, хятад хэлний тухайн үеийн хэлний онцлогийг нягтлан судлах боломжтой.

Төслийн үндэслэл, шаардлага

“Зүүн ази дахь хэл соёлын харилцаа” (*хятад, монгол, манж, солонгос хэлээр туурвисан ‘lao qida’-д тулгуурласан цогц судалгаа*) *сэдэвт эрдэм шинжилгээний төсөлт ажлын үндэслэл, шаардлагыг дараах хэдэн байдлаар тодорхойлж байна.*

1. Олон хэлний түүхэн дурсгал болох нь

Нүгөлдэй нь тухайн цаг үеийн өдөр тутмын өргөн хэрэглээний үг хэллэг, харилцан яриа бүхий ном бөгөөд хятад, монгол, манж, солонгос хэлээр уламжлан ирэхдээ тухайн хэлний үсэг бичгээрх эхийн зэрэгцээ, үг өгүүлбэрийг дуудлагыг галигчлан тэмдэглэж, орчуулгыг хадсан тул монгол, манж, солонгос хятад хэлний авианзүй, хэлзүйн түүхэн хувьсал хөгжил, үгийн утга, өнгөрсөн цаг үеийн ярианы хэлний онцлогийг судлах чухал хэрэглэгдэхүүн болно. Өнөө хэр олдсон монгол бичгийн дурсгал үлэмжхэн, харин дуудлагыг аман ярианы хэлийг тэмдэглэсэн дурсгал нэн ховор юм. Иймд энэ зохиол нэг талаар дөрвөн хэлний тус бүр түүхэн хувьсал, хөгжлийг улируулан байцаах, нөгөөтэйгүүр монгол-солонгос, манж-солонгос уламжлалт орчуулгыг шинжлэн судлах чухал эх хэрэглэгдэхүүнд зүй ёсоор тооцогдоно.

2. Зэрэгцүүлсэн ба харьцуулсан хэл шинжлэлийн баримт хэрэглэгдэхүүн болох нь Нүгөлдэй нь төрөл бус хятад хэлний эхийг монгол, манж, солонгос хэлний эхтэй хэлний дурсгалын хувьд жишин судлах эх хэрэглэгдэхүүн болох тул зэрэгцүүлсэн хэл судлалын; мөн Алтай овгийн хэлэнд багтах монгол, манж, солонгос зэрэг төрөл хэлний баримтыг өөр

хооронд нь жишин судлах хэрэглэгдэхүүн болохын хувьд харьцуулсан хэл шинжлэлийн эх сурвалж болно.

3. Нийгэм хэл шинжлэлийн судалгааны хэрэглэгдэхүүн болох нь

Уг зохиол нь нэгд 13-14 зууны үеийн худалдаачин хүний аж төрөл, худалдаа наймааны хэрэг, аян замын үйл явдлыг харилцан яриагаар дүрсэлж, тухайн үеийн нийгмийн нөхцөл байдал, хүмүүсийн хоорондын харилцааны нийтлэг хэв маягийг тусгасан хоёрт, өөр өөр улс үндэстний хоорондын харилцаанд хамаарах өгүүлэмжтэй учир нийгэм хэлшинжлэлийн талаас судлах чухал эх сурвалж юм.

4. Соёлын харилцааг судлах баримт болох нь


Зохиолын хэрэг явдал, өгүүлэмж Юань улсын үед холбогдоно гэдэг дээр судлаачид санал нэгтэй байдаг. Нүгэлдэй бичиг бол Юань улсын үе болон түүнээс хойш 17-р зууны үе хүртэл Монголчуудын сүр нөлөө хүчтэй байсан, цаашилбал, 10-р зууны үед Хятанчууд Ляо улсыг байгуулан Зүүн Хойд Азийг /Умард Хятал, Солонгос, Манжуур, Монголын нутаг/ бүхэлд нь эрхшээж байсан түүхэн нөхцөл байдалтай шууд холбоотойгоор бий болсон зохиол учир нүгэлдэй бичгийг олон талаас нь эх бичгийн судалгаа хийх нь монгол, манж, солонгос, хятад үндэстний соёлын харилцааг судлах чухал баримт хэрэглэгдэхүүн болох юм.

Төслийн ач холбогдол

Монголын судлаачид “Нүгэлдэй”-н судалгаатай нэлээн хожуу танилцсан тул харьцангуй шинэхэн судалгаа гэж үзэж болох бөгөөд манай хэл шинжээчид, ялангуяа төслийн багийнхан тус тусдаа бие даан судалж эхлээд байна. Тус төслийн хүрээнд солонгос, хятад, монгол, манж хэлээрх “Нүгэлдэй”-г хэл тус бүрээр нь авиа зүй, үг зүй, үгийн сан, өгүүлбэр зүй, найруулга зүй түвшинд задлан судлахаас гадна олон хэлний дуудлагыг солонгос хэлээр буулгасан галигийн онцлогт тулгуурлан тэдгээр хэлний авианы онцлогийг нарийн тодруулах чухал судалгаа болно. Нөгөөтэйгүүр тухайн үеийн нийгэм цаг үеийн байдал, ахуй амьдралыг тодорхой хэмжээгээр тусгасан сурвалж учраас нийгэм хэлшинжлэлийн талаас ч судлах болно. Төслийн үр дүнд гарах нэг иж ном өдгөө монгол хэл сурч судлаж байгаа (*тухайлбал, БНСУ, Хятад, Япон, Монгол Улсын их дээд сургуулийн оюутан судлаачид*) дотоод гадаадын судлаачдад чухал хэрэглэгдэхүүн болно.

Төслийн судалгааны эх хэрэглэгдэхүүн

Тус судалгаанд дараах гурван эх сурвалжийг гол болгон ашиглах бөгөөд холбогдох судалгааны бүтээлүүдийг үзэж судална. Мөн төслийн үр дүнд гарах гурван номд тухайн судалгаанд хамаарах нийт судалгааны бүтээлийн жагсаалтыг хамтатган хавсаргах болно.



Хятад Lao qida-г хамгийн анх 1346 онд сүүлчийн хэвлэлийг 1795 онд хэвлэсэн.

Хятад хэлээр дөрвөн эх буй.

1346 оноос өмнөх

1483 оны эх

1761 оны эх

1795 оны эх



『蒙語老乞大/монөногөлдай/』, 『清語老乞大/цөноногөлдай/』 хоёр эх нь Корёогийн үеэс хэрэглэдэг байсан хэлний сурах бичиг 'Одоогийн 『蒙語老乞大/монөногөлдай/』, 『清語老乞大/цөноногөлдай/』 нь 8 боть, модон бараар хэвлэсэн ном. Агуулгын ихэнх нь адил төстэй.



Чосөн хааны сүүл үе (1800)-д манж хэлний сургалтад хэрэглэхээр хэвлэсэн манж хэлний харилцан ярианы сурах бичиг юм. 8 боть 8 дэвтэр. Модон барын хэвлэл. Өдгөө байгаа эх нь 1765 онд Ким Чин Ха /김진하/ нэмэн засварлаж Хойд Солонгост хэвлэсэн завсарын эх юм.

Үүнээс гадна өнөө хэр тус төслийн судлаачдаас уг судалгаанд хамаарах дараах бүтээлүүдийг хэвлэн гаргажээ.

1. Маналжав, Л. *Зүүн Ази дахь соёлын харилцааны жишээ: “ Нугэлдэй ”(Lao qida)*, Олон Улсын Монголч Эрдэмтэдийн 11 их хурал, Монгол Улс, 2017.

2. Otgontuul, T . Choi Dung Guen, *"Mong- ô nogôltae"* ISBN 978-89-93664-10-2, Korea, 2009.

3. Otgontuul, T *"A Comparative Study of Case Suffixes of Korean and Manchu"*—with a special reference to Chong-o-Nogoldae, Sangji University, Korea, 2003. (магистрын зэрэг горилсон бүтээл)

4. Otgontuul, T *"A Comparative Study of Case Suffixes of Korean, Mongolian, Manchu"*
Dissertation of Ph.D, Sangji University, Korea, 2009.

5. Отгонтуул, Т. *“Чосөн улсын үед хэрэглэж байсан манж хэлний сурах бичгүүд”*, МУИС, ГХСС-ийн Солонгос судлалын тэнхимээс зохион байгуулсан “Солонгос судлал- 20 жилд” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, 2011. / *хурлын эмхтгэлд*/.

Төслийн бүрэлдэхүүн

Төслийн судалгааны эх сурвалж болох Нугэлдэй хэмээх ном бол судлаачаас эртний хятад хэл, дундад үеийн монгол, солонгос хэл, мөн манж хэлний мэдлэг чадвар шаардсан судалгаа тул төслийн багийн бүрэлдэхүүнд дараах судлаачид оролцов.

Төслийн удирдагч Т.Отгонтуул /хэл бичгийн ухааны доктор, профессор/
МУИС-ийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхимийн багш, МУИС-д манж хэлээр мэргэшсэн эх бичиг судлаач мэргэжлээр бакалавр, “Монгол- Манж толь бичгийн судалгаа” сэдвээр магистрт тус тус хамгаалсан. БНСУ-д “Монгол солонгос хэлний тийн ялгалын харьцуулсан судалгаа -нугэлдэйн жишээгээр-” сэдвээр магистр, “Солонгос- монгол-манж хэлний тийн ялгалын харьцуулсан судалгаа” сэдвээр хэл бичгийн ухааны докторын зэргийг хамгаалсан. Манж, монгол сурвалж судлал, харьцуулсан хэл шинжлэлээр судалгаа хийдэг.

Төслийн зөвлөх: Л.Маналжав /хэл бичгийн ухааны доктор, профессор/
Академич Б.Ринчений удирдлагаар “Монголын Нууц Товчооны хэлний хэлний авиалбарын тогтолцоо” сэдвээр судалгааны ажил хийж, дэд эрдэмтний зэрэг хамгаалсан, эртний хятад ханз, монгол бичгээрх сурвалж судлалаар ажилладаг, хятад, англи, орос хэлтэй.

Төслийн гүйцэтгэгчид:

М.Баярсайхан /хэл бичгийн ухааны доктор, профессор/
17-р зууны үеийн түүхэн сурвалжийн нэг Эрдэнийн товчийн эх бичгийн судалгаа, үгийн сангийн онцлогийг судалж докторын зэрэг хамгаалсан. Манж, монгол хэл бичгээрх сурвалж судлал, харьцуулсан хэл шинжлэлийн чиглэлээр судалгаа хийдэг.

Э.Жаргалмаа /МУИС, докторант/. Манж хэлээрх сургаалын зохиолуудыг Судалж магистрын судалгааны ажил хамгаалсан, монгол, манж сурвалжийн судалгаагаар ажилладаг.

Квон СонХунь /МУИС-ийн багш, докторант/
Ази судлалын тэнхимийн багш, монгол, солонгос хэлний орчуулга судлал, харьцуулсан судалгаа хийдэг, туршлагатай судлаач

Жү Сүхён /МУИС, докторант/
МУИС-ийн магистр. Монгол судлаач. Орчин цагийн монгол солонгос хэлний судалгаагаар магистрын зэрэг хамгаалсан, МУИС-ийн докторын сургалтыг дүүргэж,

манж, монгол, солонгос хэлээрх нугэлдэйн судалгаагаар эрдмийн ажил бичиж докторын зэрэг горилсон.
Тус төслийн хүрээнд дараах ажлыг хийхээр үр дүнгийн даалгаварт тусгасан болно.

ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР 1. (2018 ОН)

1.1. Олон Улсын эрдэм шинжилгээний хурал

Тус судалгааны төслийн багийн гишүүд төсөлд батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу судалгааг гүйцэтгэж ирсэн бөгөөд 2018 онд төслийн сэдэвт хамаарах “Зүүн Ази дахь хэл соёлын харилцаа: Хос хэлний сурвалж судлал” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2018 оны 7 сарын 28, 29-ний өдрүүдэд Монгол Улсад амжилттай зохион байгуулсан. Хурлын төсөв, зарцуулсан зүйлсийн тооцоог санхүүд тушааж тооцуулсан.

Тус эрдэм шинжилгээний хурлыг МУИС-ийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим хариуцан, хамтран зохион байгуулагчаар БНСУ-ын Хос хэлний сурвалж судлалын олон улсын нийгэмлэг, МУБИС-ийн Монгол хэлний тэнхимийн багш судлаачид ажиллав.

Хуралд Япон, Хятад, Монгол, Солонгос, Унгар, ОХУ-ын улсын дараах эрдэмтэд оролцож илтгэл хэлэлцүүлсэн.

1. БНХАУ-ын Бээжингийн Их сургуулийн профессор Жан Шипин
2. БНСУ-ын Гурё Их сургуулийн профессор Жон Гуан
3. БНСУ-ын ХХСОУН-ийн захирал, доктор Квон Иньхань
4. Япон улсын Кютогийн Их сургуулийн доктор Пак Жиньван
5. Япон улсын Осакагийн их сургуулийн зочин багш, доктор М.Баярсайхан
6. БНУУ-ын Элтэ Их сургуулийн доктор Коваш Рамона
7. ОХУ-ын Буриадын Их сургуулийн багш, доктор Халхарова
8. БНСУ-ын Санжи Их сургуулийн багш, доктор Жан Хяншил
9. БНСУ-ын Сүвоны Их сургуулийн багш, доктор Жон Сөнхе
10. Доктор, профессор Л.Маналжав
11. МУБИС-ийн багш, доктор П.Эрдэнэтуяа
12. МУИС-ийн багш, докторант Квонь Сонхүн
13. МУИС-ийн багш, доктор Т.Отгонтуул
14. МУБИС-ийн докторант Квон Ирү
15. МУИС-ийн докторант Жү Сүхён
16. МУБИС-ийн багш, доктор Ш.Баттөгс
17. МУБИС-ийн багш, доктор Д.Ганболд

18. МУБИС-ийн багш, доктор Л.Жумдаан нар илтгэл хэлэлцүүлээ.

Хуралд төслийн сэдэвт холбоотой судалгаа хийдэг гадаад, дотоодын их дээд сургуулийн багш, судлаач оюутнууд оролцож судалгааны чиглэлээр санал солилцов.

東北亞言語文化交流-“譯學과 文字”- 國際學術會議
ЗҮҮН АЗИ ДАХЬ ХЭЛ СОЁЛЫН ХАРИЛЦАА-“ХОС ХЭЛНИЙ СУДЛАЛ БА
БИЧИГ ҮСЭГ”-
ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИХ ХУРАЛ

● 主催 / Зохион байгуулагч

國際譯學書學會 / Хос Хэлний Сурвалжийн Олон Улсын Нийгэмлэг

蒙古國立師範大 / МУБИС, НХУС, Монгол хэлний тэнхим, Монгол судлалын төв

蒙古國立大 / МУИС, Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхим

蒙古滿洲學會 / Монгол дахь Манж судлалын холбоо

日時: 2018年 7月 28日(土) ~ 7月 29日(日)

Хэзээ: 2018 оны 7 Сарын 28(Бямба)-наас 29(Ням)-нд

場所: 蒙古國立師範大 本館 會議室

Хаана: МУБИС-ийн төв байрны хурлын танхим

7月28日(土) 第1日次 / 7 сарын 28(Бямба)-н I өдөр

9:00 ~ 9:30 開會式 / Хурлын нээлт

司會: 李準煥(韓國 昌原大) / Нээлт удирдагч: Ли Жүнь Хвань

● 開會辭 / Нээлтийн үг

權仁瀚(國際譯學書學會 會長) / Квонь Инь Хань (ХХСОУН-ийн Захирал)

바트바타르(몽골국립사범대 인문사회대학장) / Ж. Батбаатар (МУБИС)

● 기념사진 촬영 / Дурсгалын зураг авахуулах

9:30 ~ 12:00 企劃 發表 / Нэгдсэн хуралдаан

司會: 바트투스(몽골국립사범대) / Хурал удирдагч : Ш. Баттөгс(МУБИС)

- 鄭光(韓國 高麗大) / Жон Гуан (Гурё-гийн их сургууль)

“司譯院 譯學書의 諸 文字 - 偉兀眞, 帖兒月眞, 伊路波, 滿洲字를 중심으로-”

“Са Ёг Вонис эмхэтгэн хэвлэсэн хос хэлний сурвалжийн бичиг үсгүүд – Уйгаржин, Дөрвөлжин, Ируха, Манж үсгийн жишээгээр -”

- 张西平(中國 北京外國語大) / Жан Ши Пин(Бээжингийн гадаад хэлний их сургууль)

“摇摆于欧洲与中国之间：《中国哲学家孔》翻译研究”

“Европ, Хятад хороондын хандлагын ялгаа : 《Гүн ухаантан Күнз》-ийн орчуулгын судалгаа”

- 마날잡(몽골국립대) / Л. Маналжав (МУИС)

“漢語《老乞大》의 中文 研究”

“Нүгөлдэй буюу 《ЛаоКида》-гийн хятад эхийн судалгаа”

12:00 ~ 13:30 點心食事 / ҮДИЙН ЗООГ

13:30 ~ 15:00 午後 發表 1: 歷史 文化 / Хуралдаан 1: Түүх, угсаатны зүй

座長: 張香實(韓國 尚志大) / Хурал удирдагч: Жан ХянШил (Санжи их сургууль)

- 權仁瀚(韓國 成均館大) / Квонь Инь Хань (Сонгюньгуаны их сургууль)

“新出土 新羅木簡에 대한 言語文化史的 研究”

“Шинэ олборлосон Шила улсын үеийн модон дээр бичсэн номыг хэл, соёлын үүднээс судлах нь”

- 바트투스(몽골국립사범대) / Ш. Баттөгс (МУБИС)

“몽골인의 時間測定方式과 해시계”

“Монголчуудын цаг хугацааг баримжаалах ёс ба наран цаг”

- 鄭丞惠(韓國 水原女大) / Жон Сөн Хе (Сүвоны их сургууль)

“古代의 通譯과 譯官”

“Эрт үеийн хос хэлний судлал ба судлаач”

15:00 ~ 15:30 休息 / ЗАВСАРЛАГА

15:30 ~ 17:30 午後 發表 2: 譯學 / Хуралдаан 2: Хос хэлний судлал

座長: / 권성훈(몽골국립대) / Хурал удирдагч: Квонь Сон Хүн (МУИС)

- 오트경톨(몽골국립대) / Т. Отгонтуул (МУИС)

“滿洲語 한글傳寫의 特徵 - 《清語老乞大》의 事例”

“Манж хэлийг хангыл үсгээр тэмдэглэсэн онцлог – 《Чонг-О нугөлдэй》-н жишээгээр”

● 에르데네토야(몽골국립사범대) / П. Эрдэнэтуяа (МУБИС)

“몽골어의 親族名稱 考察 - 《蒙語老乞大》, 《蒙語類解》의 事例”

“Монгол хэлний төрөл садны нэрийг шинжих нь - 《Мун-о-Нугалдай》, 《Мун-о-Юүхэй》-н жишээн дээр”

● 권일우(몽골국립사범대) / Квонь Иру(МУБИС)

“《清語老乞大》와 《蒙語老乞大》의 句文比較 - 語法에 어긋난 《捷解蒙語》의 句文을 중심으로”

“《Манж лао кида》, 《Монгол лао кида》-гийн өгүүлбэрийг харьцуулах нь - 《Цоге Мун-о》-гийн дүрэм бус бүтцийн жишээн дээр”

18:00 晚餐 / ОРОЙН ЗООГ

7 月 29 日(日) 第 2 日次 / 7 сарын 29(Ням)-н II өдөр

9:30 ~ 11:30 午前 發表 세션 I: 歷史 文化 / I Салбар хуралдаан: Түүх, угсаатны зүй

座長: 송의민(몽골국립사범대) / Хурал удирдагч : Сун ЙыМинь (МУБИС)

● 李準煥(韓國 昌原大) / Ли ЖүньХвань (Цанвоны их сургууль)

“池錫永《兒學編》의 漢語 表記와 漢語音”

“Жи Сог Ён-ы зохиосон англи хэлний сурах бичиг дэх хятад үгс”

● 강볼드(몽골국립사범대) / Д. Ганболд (МУБИС)

“티베트語로 作成된 蒙文法書의 內容 概要”

“Төвөдөөр бичсэн монгол хэлзүйн нэгэн судар, түүний агуулгын товч”

● 朴眞完(日本 京都産業大) / Пак Жинь Вань(Кютогийн их сургууль)

“19 世紀末~20 世紀初의 終結語尾 ‘-(으)오’와 ‘-요’의 關聯性에 대한 考察”

“XIX-XX зууны эх үеийн солонгос хэлний үйл үгийн төгсгөх нөхцөлийн судалгаа”

● 줌다안(몽골국립사범대) / Л. Жумдаан (МУБИС)

“몽골書藝의 起原과 變化發展”

“Монгол уран бичлэгийн үүсэл, хөгжил”

9:30 ~ 11:30 午前 發表 세션 II: 譯學 / II Салбар хуралдаан: Хос хэлний судлал

座長: 오트경틀(몽골국립대) / Хурал удирдагч : Т. Отгонтуул (МУИС)

- 권성훈(몽골국립대) / Квонь СонХунь (МУИС Ази судлалын тэнхим)

“《蒙語老乞大》 몽골어의 音韻論的 特徵”

“《Монгол нугэлдэй》-н монгол хэлний авиазүйн онцлог”

- 바야르새항(日本 大阪大) / М. Баярсайхан(Осакагийн их сургууль)

“《蒙語老乞大》와 《淸語老乞大》의 比較”

“Монгол · манж нугэлдэйн харьцуулал”

- 바트히식(몽골국립대) / С. Батхишиг (МУИС)

“《蒙語老乞大》의 蒙文과 한글表記의 比較”

“《Мун-О нугэлдэй》-н монгол бичгийн эх ба хангыл эхийг харьцуулах нь”

- 주수현(몽골국립대) / Т. Отгонтуул , Жү Сү Хён (МУИС)

“滿洲語와 韓國語의 請誘·命令語尾 比較 - 《淸語老乞大》의 事例”

“Манж Солонгос хэлний хүсэх, захирах нөхцөлийг харьцуулах нь - 《Манж нугэлдэй》-н жишээгээр”

11:30 ~ 12:00 閉會式 / Хурлын хаалт

司會: 李準煥(韓國 昌原大) / Хаалт удирдагч: Ли Жүн Хвань

- 閉會辭 / Хаалтын үг

바트투스(몽골국립사범대 몽골어학과장)/Ш. Баттөгс (МУБИС)

강치맥(몽골국립대 몽골어학과장)/Л. Ганчимэг (МУИХ)

14:00 ~ 15:00 蒙古國立圖書館 “稀貴書 保管室” 觀覽 / Монголын Үндэсний Номын Сангийн

“Дэлхийд бүртгэлтэй ховор номын үзэсгэлэн” үзэх

15:30 ~ 16:30 蒙古國立歷史博物館 觀覽 / Монголын Үндэсний Түүхийн музей үзэх

7月30日(月) 第3日次 / 7 сарын 30(Даваа)-н III өдөр

- 근교 답사

7세기돌궐비문 유적지

칭기스칸 전망대

Тус хуралд төслийн судлаачид судалгааны ажилтай холбоотой илтгэл хэлэлцүүлэв.

1. Доктор Л.Маналжав “Нүгэлдэй буюу ЛаоЧида-гийн хятад эхийн судалгааны тухай”
2. Доктор Т.Отгонтуул “Манж хэлний дуудлагыг хангыл үсгээр тэмдэглэсэн онцлог (Чонг-О нүгэлдэйн жишээгээр)”
3. Доктор М.Баярсайхан “Монгол ба манж нүгэлдэйг харьцуулсан зарим ажиглалт”
4. Докторант Жү Сүхён, Т.Отгонтуул “Чонг-о нүгэлдэйд гарч буй манж солонгос хэлний захирах хүсэх төлөвийн харьцуулал”
5. Докторант Квон Сонхүн “Монг-о нүгэлдэйн зохиогчид нөлөөлсөн монгол хэлний авиа зүйн онцлог” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлэв.

Л.МАНАЛЖАВ. “НУГӨЛДЭЙ БУЮУ ЛАОЧИДА-ГИЙН ХЯТАД ЭХИЙН СУДАЛГААНЫ ТУХАЙ”

1. Солонгосын гадаад хэлний сургалтын түүхээс

Ази тивийн эртний соёлт орны нэг Солонгос нь тус тивийн зүүн хойт хэсэгт оршдог бөгөөд түүхэн туршид баруун талдаа Хятадтай, зүүн хойт талдаа Хүннү, Сяньби, Түрэг, Хятан, Жүрчид, Монгол, Манж зэрэг нүүдэлчин улс гүрнүүдтэй болон өмнөд зүгт Японтой хаяа дэрлэн амьдарч иржээ. Ийнхүү хоёр мянган жилийн туршид солонгосчууд төр улсынхаа аюулгүй байдлын төлөө эдгээр гүрэн улстай зохих харилцаатай байх шаардлага ямагт тулгарч ирсэн байна. Улмаар эдгээр хөрш ард түмэнтэй дипломат харилцаатай байх нь Солонгос гүрний аюулгүй байдлын чухал зорилтын нэг байжээ.

Уламжлалын дагуу Солонгосын сүүлийн төр улсуудын үед, тухайлбал, Чосөн улсын үед гадаадын хүмүүстэй харилцах бодлого нь Sadae Kyorin/事大交鄰 их хүчин зүтгэж, хөршүүдтэй найрсаг харилцах/ гэсэн томъёллоор тодорхойлогддог байв. Энд нэг зүйлийг онцгойлон дурдах нь зүйтэй. Гадны хүчний довтолгооны үед солонгосчууд өөрийн амин чанар /identity/ улс орныхоо нэгдмэл байдлыг ямагт хадгалж байсан бөгөөд гол гол төр улсууд нь харьцангуй удаан хугацаанд оршин тогтнож байв. Солонгостой айл хөрш бүх улс гүрнүүд хэл соёлын хувьд солонгосчуудаас ялгаатай. Иймд Солонгосын төр улсад хөршүүдтэйгээ харилцахын тулд бэлтгэгдсэн орчуулагч, хэлмэрч нар шаардлагатай байсан нь ойлгомжтой. Солонгосын түүхэнд орчуулгын ажлыг хариуцдаг алба байгуулж байсан тухай тэмдэглэл 10-р зуунаас эхтэй бөгөөд хамгийн эртнийх нь гэвэл Sadae /史臺 / энэхүү ажлыг хариуцаж байжээ. Харин Корёгийн Ch’ungnyol wang (1274-1308) –гийн 2-р онд хятад, монгол хэлээр орчуулдаг албыг байгуулсан нь T’onmungwan’gwan (Office of interpretation) ажээ. Улмаар Корё төр улсын үед Tongmungwan-ыг Sayogwon болгон өөрчлөн байгуулжээ. Харин хэдэн онд өөрчлөн байгуулсан тухай тэмдэглэл үгүй боловч, бусад үйл явдалтай харьцуулан үзэхэд 1276-1389 оны хооронд байгуулсан гэж судлаачид үздэг¹.

¹ Song Ki Jong: The Study of Foreign Languages in Choson Dynasty (1392-1910), Jimoondang publishing company, Seoul, Korea, 2001.

Орчуулгын хүрээлэн (Sayogwon) –гээс гадна Sun mun won (承文院) нэртэй өөр нэгэн гадаад харилцааны албан ёсны баримт бичиг боловсруулах ажлыг хариуцдаг байгууллага байв. Чосөн төр улсын үед гол нь Хятадын Мин болон Чин улсад илгээх албан бичгийг боловсруулдаг байв. Энэхүү байгууллагын онцлог нь хятад бичгийн хэлийг стандарт болгон хэрэглэдэг байсан учир ярианы хэлийг сургахад онцын үүрэггүй байжээ. Албан ёсны бичгийн журам болох Imun (吏文), мөн хятадын бичгийн хэл (солонгосоор hanmun 漢文, хятадаар 文言) байв.

Дээр дурдсан энэхүү хоёр байгууллага Солонгост орчин цагийн өөрчлөлт, шинэчлэлт эхэлсэнтэй холбогдон 1894 он гэхэд хаагдсан байна. Энэ үеэс эхлэн Солонгос улсад англи, франц, герман, япон хэлний сургалттай орчин үеийн сургуулиуд нээгдсэн ажээ.

Чухамхүү орчуулгын хүрээлэн Sayog won-д хятад, монгол, журчень (манж) хэлийг зааж сургаж байв. Эдгээр хэлийг сургахад хэрэглэж байсан ном, толь бичгийн дотроос “ Ногулдай” (Лао Чида), “Пак тонса” гэсэн ном гол хэрэглэгдхүүн болж байв. Эдгээр хоёр номыг хятад хэлээр анх бүтээсэн, хожим нь тэдгээр номын хувилбарыг орчуулсан хэмээн судлаачид үздэг.

“Лао чида”-тай нэгэн зэрэг мөн хятад хэлээрх “Пак Тонса” хэмээх номыг хамтад нь авч үздэг. Энэ хоёр бүтээлийг Хятад, Япон, Солонгосын эрдэмтэд нэлээд судалжээ. Харин Монгол улсад анх удаа 1959 онд Монгол хэлбичгийн эрдэмтдийн анхдугаар хуралд тавьсан илтгэлдээ профессор Хон Гимун дурдсан билээ. Хэдүйгээр ийнхүү монгол “Ногулдай”-тай нэлээд хожим танилцсан боловч, манай залуу судлаачид эдүгээ анхаарлаа хандуулж байна.

2. Хятад хэлээрх “Лао Чида”-гийн тухай

Энэхүү бүтээл нь зөвхөн хятад хэлээр бичсэн, бас солонгос хэлний орчуулга гэсэн хоёр хувилбартай. Номын бүтэц нь дээд, доод хоёр дэвтэр, найман бүлэгтэй. Хятад эхийг уншихад жирийн аян замын тэмдэглэл мэт боловч, үйл явдлыг амаар ярьж байгаа мэт сэтгэгдэл төрнө. Энэ нь хүмүүсийн ярьсан зүйлийг тэмдэглэсэн мэт сэтгэгдэл төрүүлнэ. Ялангуяа юмны нэрийг (хамаатан садан, эм, ургамал, хоол унд, бүс бараа, эрдэнэсийн зүйл, нум сум, адууны зүс г.м.) тоочиж байгаа нь үлгэр ярьж байгаа мэт, нөгөө талаас үгсийн санг баяжуулахад тус болохоор баялаг үгтэй. Энэхүү номыг ярианы сурах бичиг болгон зохиогоогүй, харин ярианы хэлээр бичсэн номыг хятад болон бусад хэлийг сурахад хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байсан юм биш биз?

“Лао Чида” ном уламжлагдан ирсэн түүхэн он дараалалыг товчоолон харуулбал:

1. “Лао Чида” номын талаарх тодруулга

Хүснэгт 1

№	Агуулга	Хугацаа	Тодруулга
1	Зохиогчийн холбогдолтой Мэдээ	至正六年 (1346)	Бү Шюй (不虛和尚！至正六年丙戌春入都)
2	老、朴 Хоёр номын тухай	世宗五年 (1423)	世宗實錄卷二十, 世宗六年 (1424) 世宗五年六月候
3	老、朴 Хоёр номыг солонгос хэлэнд орчуулсан тухай авианы үсгээр галигласан	1515 оны үед	Cho'e Sejin (崔世珍) хоёр номыг солонгос хэлэнд орчуулж,
4	Одоо хадгалагдаж байгаа Юань, Мин улсын үеийн хятад хэлний эхүүд Мин улсын эхэн үе онцлог		1480-1483
5	老乞大諺解 (上下)	。 。 。	(1670)

Энэхүү хоёр номын зохиогч тодорхойгүй. Харин Пак Тонса номын дотор Пү (Пак) овогтны тухай нэгэн мэдээнд: “步虛俗姓洪氏，高麗洪州人，法名普愚，初名普虛，號太古和尚，有求法於天下之誌，至正丙戌春入燕都。”至正丙戌為元順帝至正六年 гэдэг нь Тогоонөмөр хааны хаанчлалын нэр, 丙戌 он бол түүний 6-р он буюу нийтийн тоололын 1346 он. Тэрээр Дайду буюу (燕京) хотод иржээ. Харин хоёр номын тухай 1423 оноос Солонгост дурдах болсон. Ийнхүү хоёр номыг зохиоход Пү овогт хамаатай байж болох, тэдгээрийг 1446-1423 оны хооронд бүтээсэн гэж үзэж болохоор байна. Харин 1515 онд Cho'e Sejin (崔世珍) солонгос хэлэнд орчуулж, авианы үсгээр галиглажээ (Зураг 1. 老乞大諺解 Ли Фангүй профессорын хэвлүүлсэн эх)

“Ла Чида”-г хятад хэлний түүхийг судлахад чухал эх сурвалж гэж хятад судлаачид үздэг. Юуны өмнө, хятад хэлний авианы тогтолцоог судлахад маш чухал ач холбогдолтой. Хоёр номын солонгос бичгийн галиг нь тухайн үеийн хятад хэлний хойт зүгийн аялгууг тусгас-наараа орчин цагийн хятад хэлний түүх судлалд чухал хэрэглэгдэхүүн болж өгнө. Хятад хэлний түүхийг үечлэн хуваахдаа хятадын эрдэмтэд янз бүрийн саналтай байдаг бөгөөд Бээжингийн Их сургуулийн профессор 唐作藩 багшийн саналаар хөгжлийн үе шатыг хуваахдаа ойрхи үеийн хятад хэл (近代汉语) хэлийг XIII – XIV зуунаас 1919 он хүртэл (5-р сарын 4-ний хувьсгал), орчин үеийн хятад хэлийг 1919 оноос өнөөг хүртэл гэж үздэг билээ. Энэхүү саналыг хятадын олонхи хэлшинжлэлчид баримтладаг нь оновчтой гэж үзэж байна.

3. Хятад хэлний авиазүйн онцлог

Хятад хэл нь авианы бус утгын бичиг үсэгтэй тул хятад хэлний авиазүйн тогтолцоог судлахад бэрхшээлтэй байдаг. Ялангуяа эртний хятад хэлний авиаг сэргээхэд нэг талаар одоогийн нутгийн аялгуу, нөгөө талаар өнгөрсөн үеийн аялгууны толь бичиг, шүлгийн айзам зохиох толь, авианы зураглал, шүлэглэсэн зохиол зэрэгт тулгуурладаг. Үүнээс гадна харь хэлээр бичсэн эх бичгүүд доторхи хятад үгээр өнгөрсөн үеийн эртний авиаг сэргээх бас нэг арга бий. Энэ үүднээс авч үзэхэд “Лао Чида” номын солонгос үсгийн галиг нь одоогоос 4-5 зуун жилийн өмнөх хойт зүгийн аялгууны авиаг сэргээх, авианы тогтолцоог судлахад үнэлж баршгүй эх сурвалж юм. “Лао Чида” нь зөвхөн авиаг судлаад зогсохгүй, тэр үеийн амьд ярианы хэлийг судлах чухал хэрэглэгдэхүүн юм.

1515 оны орчим хятад хэлшинжлэлч Cho'oe Sejin (崔世珍) өгүүлж байгаа хоёр номыг орчуулж, солонгос авианы үсгээр галигласан байна. Үүнд хоёр төрлийн дуудлагаар галиглахдаа зүүн талд нь 15-р зууны хойт зүгийн аялгуугаар галигласан бол, баруун талд нь Choe Sejin өөрийнх нь амьдарч байсан 16-р зууны үеийн аялгуу болох 今僧音 -р тэмдэглэжээ. Баруун талд тэмдэглэсэн энэхүү 今僧音 -ийн авианы тогтолцоо нь 韵略易通 (1442 он) –той ойролцоо гэж хятадын хэлшинжлэлчид үздэг. Галигаас харахад тэр үед үеийн эхний авиа (声母) 20 байсан бөгөөд үе хаадаг буюу дэвсгэрлэгч гийгүүлэгч -р, -t, -k, (入声韵尾) гээгдэж, үе хаадаг -m нь -n-ээр солигдсон байдал ажиглагддаг.

4. Үгийн сангийн онцлог

Урт удаан хугацаанд энэхүү бүтээл нь олон дахин хэвлэгдэж байснаас дөрвөн төрлийн хэвлэлтийг судлаачид харьцуулан судлаж байна. Үүнд:

原本老乞大	(1346 оноос өмнө)
老乞大諺解	(1483 оны үе)
老乞大新解	(1761 он)
重刊老乞大	(1795)

Судлаачид 老乞大-гийн үгийн санг ойрхи үеийн хятад хэлний үгийн сантай харьцуулан үзэж, өнгөрсөн 4-5 зуун жилийн дотор хэрхэн өөрчлөгдөн ирснийг судлаж байна. Жишээлбэл, 原本老乞大-гийн хэвлэлтэнд 帖落 (торх) гэх үг дараа дараагийнхад 洒子、柳罐 (хэвлэлтийн аль алинд нь) хэмээн тааралдаж байна. БНХАУ-д дээр дурдсан

дөрвөн хэвлэлтийн үгийн санг харьцуулан хятад хэл сүүлийн дөрвөн зуугаад жил хэрхэн өөрчлөгдсөнийг үзүүлсэн судалгааны ажил нэлээд гарч байна.

Өгүүлбэрзүйн онцлог

а) Энэхүү сурвалж бичгийн хэлний өгүүлбэрийн доторхи үгсийн дэс дараа сонирхол татдаг.

Хятад хэлний өгүүлбэрийн бүтэц SVO байдаг бол Монгол болон Алтай язгуурын хэлнийх SOV. Гэтэл 老乞大 -гийн эх бичигт үйл үгээр төгссөн өгүүлбэр олон байна. Жишээлбэл:

(原本)	什么般的歹人有	
(谚解本)	为什么有这般歹人	
(原本、谚解本)	你的师傅是什么人？	
	是汉人有	(асуулт, хариулт адил)

б) 老乞大 -гийн эх бичигт олон тоог маш өргөн илэрхийлсэн.

Хүн болон хүмүүнд хамаадалгүй зүйлд хэрэглэсэн. Жишээлбэл: 原本 дотор 每 гэсэн бол дараагийн хэвлэлтүүдэд 们 болжээ. Эхний 原本 доторхи жишээ бол, 客人每、咱每、夥伴每、小人每、馬梅

с) Монгол болон Алтай язгуурын хэлний тийн ялгалыг илтгэсэн байдал ажиглагддаг. *Хүснэгт 2. Тийн ялгал*

Тийн ялгал	Монгол хэлэнд	Хятад хэлэнд
Харъяалах	- yin, -u, -un (di)	的 (di)
Өгөх орших	- dur, -tur, -da	里根底 (gendi)
Гарахын	-aca, -ca, -a, -dasa	根底 (gendi)
Заахын	-yi	根底 (gendi)
Үйлдэхийн	-bar, -iyar	依着 (yi zhao)
Хамтрахын	Luq	与、和、共 (yu, he, gong)

Жишээлбэл: 你谁根底学文来 (Чи хэнээс бичиг сурав)

高丽地面里 (Солонгос нутагт) 老乞大 Лао Чида-гийн эх бичгийн хэлийг түүнтэй нэг үеийн эх сурвалж болох Монголын Юань гүрний үеийн бичээсүүдийн хятад орчуулгын хэлтэй харьцуулан үзэхэд сонирхолтой юм. Энэхүү монгол, хятад хоёр хэлний бичээсүүдийн хятад орчуулгыг зарим эрдэмтэд (冯承钧、蔡美彪) Юаны үеийн ярианы хэл (元代白话) гэж үздэг бол эрдэмтэн Иринчин түүнийг “гүжир” орчуулга гэж нэрлэсэн. Японы судлаачид монгол хэлний шууд орчуулгын хэлбэр (蒙文直译体文章) гэж нэрлэсэн. Зарим судлаачид Лао Чида-гийн хэлийг 汉儿言语 -гийн ярианы хэл, харин Хубилай хааны үеийн зарлиг, тунхаг, албан бичгийн хятад орчуулгыг бичгийн 汉儿言语 хэмээсэн байна (Wikipedia, Aric, I, 2010). Үнэхээр Лао Чида-гийн хэл, Юаны үеийн хоёр хэлний хятад орчуулгыг харьцуулан үзэхэд өгүүлбэрзүй, үгзүй, үгийн сангийн хувьд адил төстэй зүйл олон байна.

Лао Чида-гийн хэлэнд ажиглагддаг өгүүлбэрзүй, үгзүй, үгийн сангийн онцлогийг хятад хэл, алтай язгуурын хэлтэй хавьтан ойртсоны үр дүнд бий болсон гэж зарим хэлшинжилчид үздэг. Юаны үеийн хятад ярианы хэлтэй дээрх сурвалж бичгийн хэлийг харьцуулан үзэхэд адил төстэй зүйл ажиглагддаг юм. Нэгэн цаг үед хамаарагдах 元代白话 болон Лао Чида-гийн хэлээр төлөөлүүлж болох хятад хэлний хойт зүгийн нутгийн аялгуунд суурилсан, монгол болон Алтай язгуурын хэлний нөлөө бүхий дундын хэл буюу нэгэн төрлийн ‘lingua franca’ энэ үед Зүүн хойт Азид үүссэн байж болох юм гэсэн таамаглал төрж байна. Ийм байсны баримт бол Лао Чида ном болон Монголын Юань гүрний үеийн

(голдуу дөрвөлжин үсгээр бичсэн) хоёр хэлний бичээсүүдийн хятад орчуулга юм. Ийм дундын хэл байсан учраас бичгийн эх сурвалжид тэмдэглэн үлдээжээ. Ийм нэг өвөрмөц Lingua franca –г хэсэг хугацаанд хэрэглэж байгаад хувиран өөрчлөгдөж, хятад хэлний хэм хэмжээндээ эргэн орсон байж болох юм. Гэхдээ энэ үзэгдэл бол хэлшинжлэлд сонирхолтой асуудал бөгөөд хэлний хөгжилд гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөг судлахад чухал ач холбогдолтой юм. Мөн хоёр өөр хэвшинжийн хэл хэрхэн харилцан нөлөөлж байсныг олж харж болох юм.

Энд бид хятад “Лао Чида”-гийн хэлний онцлогийн талаар товчхон танилцууллаа. “Лао Чида” буюу Ноголдайн бусад хэлээрх хувилбарууд нь мөн хэл бүрийн онцлогийг тусгасан чухал судлагдахуун юм. Энэхүү номын хятад, солонгос, монгол, манж, япон хэлний хувилбаруудыг зөвхөн хэлээр хязгаарлахгүй, түүх, соёл, худалдаа, эрхзүй зэрэг олон талаас нь судлах ажил олон орны, ялангуяа тус эрдэм шинжилгээний хуралд оролцож байгаа орнуудын судлаачдын хамтын судалгааны ажил болно хэмээн хүсэн хүлээж байна.

М.БАЯРСАЙХАН. МОНГОЛ БА МАНЖ НУГӨЛДЭЙГ ХАРЬЦУУЛСАН ЗАРИМ АЖИГЛАЛТ

Түлхүүр үг: Монгол Нугөлдэй, Манж Нугөлдэй, харьцуулал, онцлог

Тус илтгэлд монгол (蒙清語老乞大) болон манж хэлний (清語老乞大) Нугөлдай бичгийг харьцуулан тулгаж үзсэн зарим ажиглалтын талаар дурдах болно. Энэ хоёр хэлний Нугөлдай бичиг нь харилцан хамааралгүйгээр хятад эхээс орчуулсан орчуулга гэдэг билээ. Монгол, манж хэлнүүд нь өгүүлбэрийн бүтэц байгуулал ижил бөгөөд эдгээр хэлнээс харилцан орчуулсан албан бичиг, хууль цааз, түүхэн сурвалж, сургаалын зохиолын уламжлалт хэл найруулгаас авч үзэхэд, үгчилсэн орчуулга зонхилох мөртөө утга санааг алдагдуулалгүй эвтэйхэн зөв буулгаж чаддаг онцлогтой билээ. Тэгвэл 17-18 дугаар зууны үеийн ярианы хэлийг тусгасан монгол, манж хэлний Нугөлдай бичгийг агуулга, хэл найруулгын талаар харьцуулж үзвэл ямар онцлогтой болохыг тодруулах нь тус илтгэлийн зорилго юм.

Манж ба Монгол Нугөлдэйг нэгбүрчлэн тулгаж үзвэл, ерөнхийдөө агуулга, хэмжээний хувьд адил боловч, Хятадын сонгодог утга зохиол, Күнзийн суртлын бичиг номын монгол, манж орчуулга шиг бүрэн дүйж, яв цав тохирохгүй байгаа зүйл ч нэлээн ажиглагдаж байна. Монгол ба манж Нугөлдайн эхийг харьцуулбал дараах онцлогтой байна. Үүнд:

1. Хэрэглэсэн үг хэллэг, өгүүлбэрийн найруулга, утга санаа бүрэн тохирсон
2. Утга санаа, өгүүлэмж тохирох боловч хэрэглэсэн үг хэллэг, найруулга ялгаатай.
3. Утга санаа, өгүүлэмж тохирох боловч, харилцан нөхвөр болохуйц бага сага үг хэллэг орсон. Өөрөөр хэлбэл, нэгэнд нь байгаа үг хэллэг нөгөөд нь байхгүй, хураангуй ба дэлгэрэнгүй бичвэр бүхий ялгаатай.
4. Үл тохирох хэсэг. Энэ нь орхигдсон, эсвэл цаад уг хятад эх нь хоёр өөр хувилбар байсантай холбогдож болох юм.

Эдгээр онцлогийг тодорхой харъя гэвэл энэ хоёр хэлний Нугөлдайг бүрэн эхээр нь харгуулан галиглаж үзэх шаардлагатай. Гэвч нэгэн илтгэлийн хэмжээнд тэгж багтааж оруулах боломжгүй тул, цөөн хэдэн жишээгээр үзүүлье.

1. Үг хэллэг, найруулга, утга санаа бүрэн тохирч байгаа нь:

- Yeke abayai ci qanasa irebe. Bi Cookiyang wang ging-ece irebe. Odo qana ecin-e. /mo.1-1/

- Amba age si aibici jihe. Bi Čoohiyan wang ging-ci jihe. Te absi genembi. /ma.1-1/
- Tngri örüşiyejü bey-e amur bolbasu ečinem /mo.1-2/
- Abka gosifi beye elhe oci isinambi dere /ma.1-2/
- Bi ene ed-i abču Zu jeü yajar-tu qudalduq-a ečiy-e gejü bile. /mo.8-1/
- Bi ere ulin-be udafı Zu jeo bade uncame geneki sembihe /ma.8-1/
- Či saıar ügei qurdun ir-e. Diyan ger-ün ejen olon qudalduı-a kikü kümün-i abči ir-e /mo.8-2/
- Si urunakû hûdun jio. Diyan boihoji age si geren hûdai niyalma-be gajime jio. /ma.8-2/
- Ken ayisi ügei öber-e dengzi-yi kereglen-e /mo.8-3/
- We gelhun akû encu dengneku-be baitalambi /ma.8-3/

Монгол, манж Нүгэлдэйн хэлмэл бүрийн харилцан онцлог байдал жигд бус бөгөөд 8-р хэлмэлийн үг өгүүлбэрийн дийлэнх нь тохирч нийлж байхад 7-р хэлмэлийн хэл найруулга нэлээн чөлөөтэй, харилцан тохирохгүй үг өгүүлбэр ихтэй, нөхвөр болох зүйл их байна.

2. Утга санаа, өгүүлэмж тохирох боловч хэрэглэсэн үг хэллэг, найруулга ялгаатай.

- ... tegünü qüng-yi buruyu-du toyočju jančiyulqui-yi keltürigülümü /mo.1-6/
- ... nenehe šangnan-be weile-de fangkabume tantabure-be guwebumbi /ma.1-6/
- Bayarlaju suryaqu buyu suryaqu ügei üü /mo.1-8/
- Sidhûme tacibumbio, sidhûme taciburakûn /ma.1-8/
- Yirtinču-dü čöm kitad üge bišeü /mo.1-7/
- Jalan-de nikan-i gisun-be baitalara ba umesi labdu /ma.1-6/
- Činu ögülegsen üge jöb bolbači [kumun öber-e öber-e čöm medegsen yajar bui bišeü. Či yamar medegsen yajar bui. Či ögüle. Bi sonusuy-a] /mo.1-6/
- Sini hendurengge udu inu secibe [mini yûnin-de kemuni akûnahakû adali yûnimbi] /ma.1-6/
- Medekü ügei bišeü. Tere üge-yi yakiji ögülemü /mo.1-2/
- Bi adarame bahafi sambı /ma.1-2/

Харгуулбал ийнхүү үг хэллэг, найруулгын ялгаа бүхий хэсэг эхний бүрэн тохирох хэсгээс илүү хувь хэмжээтэй байна.

3. Утга санаа, өгүүлэмж тохирох боловч, харилцан нөхвөр болохуйц хураангуй ба дэлгэрэнгүй бичвэрийн ялгаа цөөнгүй. Жишээ нь:

- Či [+čookiyan kümün] [-] kitad bičig-yi surču yaukin-e /mo.1-6/
- Si [-] [+tere] nikan-i bidhe-be tacifi ainambi /ma.1-6/
- Edüge [-] qaıan beyise [-] delekei dakin-i [-] bügüde jakıruısan bai. /mo.1-7/
- Te [+bicibe] han beise [+duin mederi-be uherilefi] abkai fejergi-be [+yooni] gemu kadalajahi. /ma.1-6/
- Či ün-e-yi medenem geküle kedü-yi öggün-e.[-] Bi čimadu tabu lang tedüi öggüy-e. Sini yûnin-de udu buci teni acanambi. [+Bi sinde fulu inu burakû qomso inu burakû.] Sunja yan oci udhai tob seme teherere hûda. /mo.ma.6-5/
- Sudasu köbkelün jögelen nige adali ügei /mo.7-7/
- Sini ninggun sudala-e tuwaci degdere irurengge fuhali neigen akû /ma.7-7/

4. Үл тохирох хэсэг

- ...geli ere morin mušuri jodon-be udame gajıha. [Ere ilan niyalma eici sini niyaman hûncihin. Eici ishunde acafi jihenggeo. Onggolo jabdurakû ofi bahafi hala gebu-be

fonjihakû bihe. Te gelhun akû fonjiki. Ere age-i hala ai. Ere emke hala Gin. Mini gu-de banjha tara ahûn. Ere emke hala Lii. Mini naycu-de banjha tara ahûn. Ere emke hala Joo. Mini adaki boo -i guçu. Sini ere tara ahûn deo. Ainci aldangga mukûn-i tara ahûn deo dere. Akû. Bi jingini tara ahûn deo. Udtu ocibe suwe jugûn-i unduri balai toome yobodome fuhali targahakû. Yargiyan-i ambula weile baha kai. Be jugûn yabure-de dorolome gocishûn-i yabuha-de amu šaburame ojoro jakade tudtu jortai efihe kai. Muse taka sula gisun-be nakaki. Yasai juleri] ere udhai wase diyan, umesi bolho diyan ... /ma.1-21,22,23/

- [Udtu oci sain kai] /ma.1-10/
- [Mini tere takara niyalma-de fonjici alarangge] /ma.1-12/
- [+...fonjici mini yargiyan tašan-be bahafi saci ombi. Bi gûnici si inu mimbe holtoro niyalma waka. Ai cendeme fonjinara bab] /ma.1-26/
- [+Qana bausan bui. Šûn čing qoton qayaly-a-yin alban-u diyan gin jegeli qoyitu eteged nige tergen-ü gerte bausan bui. Kejij-e irebe. Bi öcügedür irebe.] Ene nökur ken bui. /mo.5-7/
- [+Boihoji age ume gasihyabuha seme gasara. Be genembi. Bi aiseme gasambi. Suwe gasarakû oci udhai joo kai. Eršehe-be ehe serakû oci] amasi jidere erin-de kemuni mini diyan-de jifi tatareo /3-4.5/
- [+Či kejij-e wang ging-eče mordaba. Bi dolon sar-a-yin sineder mordaba. Či wang ging-eče mordaji udaba. Yeügeji sayi kürčü irebe. Bi jam-du asar yabuju irebe.] Bidan-u ger-ün jakiy-a bainau /mo.5-7/
- Či irekü čay-tu [+bida ečige eke, yeke abay-a, yeke abay-a bergen, abay-a, abay-a bergen, egeči ükin degüü, kürgen aq-a, qoyaduyar aq-a, yurbaduyar aq-a, bergei degüü nar čöm mendu. Bultu sayin] bolai. /mo.5-5/

Эдгээр жишээний ташуу үсгээр тэмдэглэсэн хэсэг бол тухайн эхэд байгаа боловч, нөгөө эхэд ямар нэгэн шалтгаанаар орхигдсон байж болзошгүй үг өгүүлбэр юм.

Үүнээс гадна уг санаагаа гаргахдаа нэлээд чөлөөтэй өөрчилж найруулсан гэмээр хувилбар бичлэгтэй онцлог ялгаа байна. Ялангуяа 7-р хэлмэлийн доторх манж, монгол бичвэрт ийм ялгаатай зүйл цөөнгүй бий. Жишээлбэл:

Хуудас	Монгол Нүгэлдэйд	Манж Нүгэлдэйд байгааг үгчилбэл
7.11-7.14	Хүний хөвгүүн багаас сайхан сурч өслөө түшмэлийн ордод яваад бас ч түшмэл болж болно. Хэрбээр түүнийг сургавч түшмэл олохгүй болбоос бас түүний хувь зохиол биш үү. Бид эцэг эхийн санааг дагаж бусдаас доргүй болохул төдий буй за. Чиний энэ хүүхэд ч хүмүүжүүлэн дунд зэргээр явах буй за. Чи бусад юмыг ховдоглохыг байг. Хугарсан зүү гэвч авахгүй. Бусад алдсан газрыг хэлэлцэхгүй болохул зохимуй. Хэрбээр энэ мэт санаж явахул сайн болно. Эртний үгэнд номхон хүн мөнхүү сайн. Мунхаг хүн мөнхүү цалгар хэмээжээ.	Хүний хөвгүүн багаас сайныг сурч түшмэлийг дагалдан тушаасан албанд хичээн явж хэргэм олох нь хэдий үлэмж боловч, олохгүй нь мөн бий. Хэрвээ хэвийн учир байгуулсан сэтгэл үнэн, явдал төв болоод эцэг эхэд ачлалтай, ах дүүд элэгсэг, нөхөр ханьд бат, гацаа хүй, ураг төрөлд найртай, олон сууваас бусдын зөв буруу явдлыг шүүмжлэн хэлэлцэхгүй, аливаа хэрэгт завшихыг хичээхгүй, эхнээс эцэст хүртэл хүчлэн явсаар галирсхийхгүй болбоос тэнгэр өөрөө хишиг хүртээж баян эрхэм хүүхдийг хүмүүжүүлэх нь эртнээс нааш тогтсон зүй. Иймгүй болбоос биеэр ял янхад унаж хүүхэд ач нарт хилэнц ногдохгүй болбоос

<p>Хулгай хийх, хуурч хэлэлцэх, харгислах галирхийхийг байг. Түшмэлийн өмнө санан агуулсаар явж чадахгүй болбоос нэг өдөр ч олж дээр болж болохгүй биш үү. Нөхрийн хооронд өөрийн мэргэнийг өргөх, бусдын эндүүрийг элэглэхийг байг. Онгоц гэгч усанд явах байтал газарт явж үл чадмуй. Тэргээр хийнүү. Тэрэг мөнхүү усанд орохул явж чадахгүй, онгоцоор хиймүй.</p>	<p>даруй завшаан болой. Бас юун буй, баян эрхэм хөвгүүд төрөхийг дэмий эгээрвээс болмуй. Нөхрийн дотор нөхөрлөхөд онц бидний сайн явдлыг өргөж бусдын муу явдлыг элэглэхийг бай. Онгоц усанд явах бөгөөтөл газарт явж чадахгүй тул тэргэнд агуулмуй. Тэрэг мөн усанд явж чадахгүй тул огоцонд агуулмуй.</p>
--	---

Ийм илэрхий ялгаатай бичвэрийн зүйл нь цаад хятад эх нь өөр өөр хувилбар байсантай холбоотой юу, эсвэл энэ хэсгийг арай чөлөөтэй найруулж орчуулсан уу гэдгийг цаашид нягталж үзүүштэй.

Хэл найруулга

Манж Нүгөлдэйн хэл найруулга, үгийн бичлэг нь манж бичгийн хэлнээс төдий л ялгаагүй ажээ. Өөрөөр хэлбэл, манж бичгийн хэлэнд бичиж найруулдгаас огт өөрөөр бичиж найруулсан өвөрмөц зүйл харагдахгүй байна. Магадгүй энэ нь ерөөс манж бичгийн хэл бүрэлдэн тогтоод удаагүй тул аман ба бичгийн хэлний илэрхий ялгавар харьцангуй бага гарсан байсантай холбоотой байж болох юм.

Харин монгол Нүгөлдэйн хэл найруулга, үгийн бичлэг, хэрэглээ нь тэр чигтээ аман ярианы онцлогийг тусгасан нь илт байна. Зөв бичих зүйн хувьд алдаатай гэхээр бичлэгүүд нь нэгэн жигд, дахин давтагдаж байгаа нь хараахан санаандгүй ташаарсан зүйл биш, харин дуудлагаа дагаж бичсэн бичлэг болох нь тодорхой. Жишээ нь: *suruba*, *kiciyegemui* [=kiciyemüi], *čejilsen* [=čegejilegsen], *köndelgejü* [=ködelgejü], *endür* [=ene edür], *amtaqula* [=amtalaqul-a], *qoyala* [=qoyayula], *derbe* [=dörbe], *dečin* [=döčin] гэх мэт.

Монгол Нүгөлдэйд тэмдэглэсэн монгол хэл аялгуу бол тухайн үеийн зүүн монголчуудын хэл аялгууны баримт болно. Төгсгөлийн үгэнд Мүгдэнгийн жанжин яамны Боло (Булу?) гэгч хүнд үзүүлж засуулсан тухай тэмдэглэжээ. Түүнчлэн Солонгосын Монгол сургуулийн бичгийн түшмэд зүүн монголчуудын дунд очиж монгол хэл сурсан байх магадлалтай юм. Тус бичигт тухайн үеийн зүүн монголчуудын ярианы хэлэнд тохиолдож асан зарим өвөрмөц үгийг тэмдэглэжээ. Тухайлбал, манж эхэд “зовоовч” гэж бичсэн газар бүжрэглэвч (*büjireglebči* /mo.3-6/), туранхай махыг хазуу мах (*qajau miq-a* /mo.2-2/), адууны хомоолыг морийн аргал /mo.7-1/, түүж авчрахыг цөлбөж авчрах /mo.7-1/, ишигийг үнүх (эдүгээ зөвхөн янгирын ишигийг хэлэх болсон үг) /mo.6-8/, аяар гэхийг аашаар /mo.3-6/, маш, нэн, тун гэсэн утгатай газар ямагт адбиш гэж, нөхөд гэхийг нөхчүүд (олон удаа гарч буй), тэмдэглэсэн гэдэг утгыг эжэршисэн /mo.8-18/ гэх зэргээр бичжээ.

Түүнчлэн тухайн хэл аялгуу манж хэлний нөлөөнд автаж байсны баримт гэмээр цөөн бичлэг байна. Жишээ нь:

- *Či eyin kü kitad bičig-i surqula činu joriy-iyar surubau činu ečige eke čimayi sur geneü* /mo.1-7/. Энэ өгүүлбэрт өөрийн зоригоор, өөрийн дураар гэхийг чиний зоригоор гэж бичсэн нь даруй манж хэлний ‘ini cihai’, ‘ini cisui’ гэдэг үгийн хуулбар орчуулга юм.
- *Edür büri kitad-un baysi nar-un lüge nige yajar-tu bayiju bičig suruysan učir-tu baqan čidan-a.* /mo.1-8/ Манж Нүгөлдэйд “nikan i šusai emgi” гэжээ. “*kitad-un baysi nar-un lüge*” хэмээн харьяалахын тийн ялгалаар хэлбэржүүлсэн нь манж хэлний онцлогтой дүйх юм. Жич, монгол бичиг зохиол, толь бичиг сэлтэд хятад хэлний шүсай гэдэг үгийг оюутан гэж

орчуулаад хэвшсэн байтал тус зохиолд бүгд багш гэж орчуулсан байна. Энэ нь тухайн үед бичгийн хүнийг хүндлэн шүсай боловч, мөн л багш гэж энгийн харилцаанд өргөж хэлдэг байсантай холбоотой байж болох юм.

- tegünü güng-yi buruyu-du toyöciju jančiyulqui-yi keltüriгүлүмüi /mo.1-6/ Урьдын гавьяаг нь одоогийн гэмд нь харгуулан хэлтрүүлэх гэсэн утга. Гүн гэдэг нь манж хэлнээс орсон гавьяа гэсэн утгатай үг. Мөн дээр өгүүлсэн эжэршисэн (ejeršisen) гэдэг үг нь манж хэлний эжэрэ 'тэмдэглэх, ойлох' гэдэг үгээс үүссэн бололтой.

Манж ба монгол хэлээрх Нүгүлдэйг харгуулж, онцлог ялгааг нь ажиглахад эдгээр хэлээр орчуулагчид харилцан хамааралгүй, эхэлж гарсан бүтээлийг дараагийн бүтээлд ямар нэг хэмжээгээр ашиглаж лавлалт болголтгүй орчуулсан болох нь харагдаж байна.

Номзүй:

1. 정광(1998), 「清語老乞大 新釋」, 태학사.
2. Song Ki Joong, The Study of Foreign Languages in the Chosön Dynasty (1392-1910), Seoul Jimoondang, 2001. xi+212 pp.
3. 『몽어노결대』, 서울대학교 규장각 한국학연구원, 규장각 총서 어학편 (7), 2006.
4. <http://repo.komazawa-u.ac.jp/opac/collections/500/>
5. <https://ir.library.osaka-u.ac.jp/repo/ouka/all/16472/sial19-157.pdf>

Т.ОТГОНТУУЛ “МАНЖ ХЭЛНИЙ ДУУДЛАГЫГ ХАНГЫЛ ҮСГЭЭР ТЭМДЭГЛЭСЭН ОНЦЛОГ (ЧОНГ-О НУГӨЛДЭЙН ЖИШЭЭГЭЭР)”

Солонгосчууд Чосөн²-ы үед монгол хэл төдийгүй манж хэл бичгийг улс төрийн хийгээд түүхийн бусад шаардлагаар сонирхон судалж түүнд анхаарал хандуулж байжээ. Тэмдэглэгдэн үлдсэн баримтаас үзвэл Солонгос дахь манж хэлний судалгаа нь Солонгост Зөрчин³ хэлийг сурах цаг үеэс эхэлсэн гэж болно⁴.

Сэжун хааны 24 он(1442)-ы тэмдэглэлд Хятад-Монгол-Япон судлалын хамт Зөрчин хэлний судлалын тухай дурдсан мэдээ үлджээ. Үндсэн дөрвөн судлал нь хятад, монгол, япон, зөрчин хэл байсан бөгөөд Манж Чин улс төр улсаа байгуулж хүчирхэгжсэний дараа манж хэл судлалын тухай сонирхол ихээхэн өсчээ. Манж хэл судлалд хэт анхаарал тавьсанаар хятад хэлний орчуулагч ховордох болсон явдал ч гарсан байна. Ёнжу-гийн 5 он(1792)-ы тэмдэглэлд '*Орчуулагч нарын дунд хятад хэлийг суралцагч хүн алсдаа байхгүй болох шинжтэй тул манж хэлийг судалдаг 10 ажилтны дундаас гурван хүнийг сонгож хятад хэлийг сургавал зохистой*'⁵ гэж тэмдэглэсэнээс үзвэл тухайн үеийн улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалж хятад судлалаас илүү манж судлалыг чухал болгож анхаарал тавьж байсан нь тодорхой харагдаж байна.


² (1392-1910)

³ Монголоор Зөрчид гэдэг ард түмний нэр нь эртний Нангиад судар түүхнээ олон янзаар тэмдэглэн үлджээ. Гурван улс (220-280)-ын үед *илоу* /悒婁/, Умард Вэй улс /386-535/-ын үед *уцзи* /勿吉/, Сүй (589-619) болон Тан улс (618-907)-ын үед *мохэ* /靺鞨/ гэж байснаа Хятаны Ляо улс (906-1125)-ын *ньюйжээн* /女真/ хэмээн нэрлүүлэх болсон ажээ. Энэхүү *ньюйжээн* гэдэг үгийн үүслийн талаар эрдэмтэд тайлбарлахдаа одоогийн Дүнбэй нутгийн дорнод хэсэгт нутаглан байсан хамниган аймгийнханыг нэрлэдэг байсан зөрчин буюу зөрчид гэдэг нэрийн гажсан дуудлага хэмээн үздэг. Е Лүн-ли, История государства Киданей, Москва, 1979, стр 348, Ц.Шагдарсүрэн “Монголчуудын үсэг бичгийн товчоон”УБ, 2001, х 249, дам эшлэн авав.

⁴ Энэ тухай 정광(2002), 성백인(1994:126-139) нарыг лавлан үзнэ үү.

⁵ 최동권(2008), *Солонгос дахь монгол манж судлалын өнөөгийн байдал*, The Interchange and Understanding of Nomadic Culture in the 21st Century, The Korean Association for Mongolian Studies, Korea, p 83-85.

Бидний судалгааны эх болж буй манж хэлээрх ‘Чонг о нугөлдэй’ /Ch’ongö Nogöltae/ -н⁶ тухай товч өгүүлбээс, тус сурвалж нь Чосөн хааны сүүл үе(1800)-д манж хэлний сургалтад хэрэглэж байсан манж хэлний харилцан ярианы сурах бичиг юм. 8 боть 8 дэвтэр. Модон барын хэвлэл. Өдгөө байгаа эх нь 1765 онд Ким ЧинХа/김진하/ нэмэн засварлаж Хойд Солонгост хэвлэсэн завсрын эх. Угаас хятад хэлээр байсан нугөлдэйг манж хэлээр орчуулсан. Номын бүтэц нь манж бичгээр бичиж баруун талд нь манж хэлний дуудлагыг солонгос үсгээр галиглан тэмдэглэж өгүүлбэр бүрийн төгсгөлд солонгос хэлээр орчуулан хадсан байдаг. Энэ загвар нь ерөөсөө тухайн үед Солонгост ‘Са ёг вон’⁷-д хэрэглэж байсан гадаад хэлний сурах бичгийн нийтлэг хэв шинж байжээ. 1680 онд Чой Хү тэг/최후택/ нар хятад нугөлдэйг манж хэлээр орчуулж эхэлсэн бөгөөд энэ ажил нь 1684 онд бүрэн дуусчээ.⁸ ‘Чонг о нугөлдэй’ нь гэрэл зургийн эхээр хэрэглэгдэж байгаад 1703 онд Пак Чанг Юү/박창유/ нарын 6 хүн барлаж Ли Сэ Ман/이세만/ нар бичиж, хойтон жил нь буюу 1704 онд хэвлэсэн “Чон о чунг хэ” 4 зүйл 20 дэвтэр дунд багтааж анх удаа хэвлэсэн юм. Энэ хэвлэгдсэн эх өнөө уламжилж ирээгүй. Манж Чин улсаас буцаж ирсэн солонгос хүн “Чонг о нугөлдэй”-г манж хэлээр орчуулсан учраас анхнаасаа зөрүү мадагтай. “Чонг о чунг хэ” 4 зүйл дотроос хамгийн эхлээд “Чонг о нугөлдэй”-г засварлах ажил өрнөсөн. Засварласан хэвлэл нь Ким ЧинХа/김진하/ манжийн бүс нутагтай гадаад худалдааны ашигтай газар байсан Хамгёндү/함경도/-гийн Хуэрён/회령/-д байх хугацаандаа уулзсан Манж Нингүта⁹ -гийн Битоши /비터시/-гээс манж хэлний авиаг тэмдэглэн, зөв бичих дүрмийг хянан засчээ. “Чонг о нугөлдэй”-г уул эх нь болох “Хятад хэлний нугөлдэй”, “Монгол хэлний нугөлдэй”-тэй харьцуулж үзэхэд агуулга нь өөрчлөгдсөн газар хааяа таардаг. Манж нугөлдэйн тухайд дусал бинт орхигдсон газар болон өвөрмөц үгс цөөн тохиолддогийг эс тооцвол манж бичгийн хэлний зүй тогтлыг нарийн сайн тусгаж эмх цэгцтэй бичсэн байдаг. ‘Чонг о нугөлдэй’ нь бусад манж хэлний сурах бичигтэй харьцуулахад ‘Са ёг вон’-д хамгийн өргөн хэрэглэгдэж байсан манж хэлний сурах бичиг байжээ. Учир нь агуулгын хувьд өргөн, өдөр тутмын харилцан ярианы үг өгүүлбэрийг тусгасан, энгийн үг хэллэгтэй. Нөгөөтэйгүүр хятад, монгол хэлний нугөлдэйг манж хэл рүү орчуулсан тул суралцагч тэдгээр хэлний сурах бичигтэй харьцуулан сурахад хялбар дөхөм тал ч байсан байж болох талтай. ‘Чонг о нугөлдэй’ нь манж үг тус бүрийн хажууд солонгос хэлээр тухайн үгийн дуудлагыг тэмдэглэж, өгүүлбэр тус бүрийн доор 18-р зууны солонгос хэл (근대국어, *Early modern Korean language*)-ээр орчуулсан байдаг.



Манж хэл: amba age si aibiçi jihe.

Солонгос дуудлага: 암바 아거 시 애비치 지허.

Орчуулга: 큰 형아 네 어디로셔 온다 <청노 1:1a>

⁶ ‘Чонг о нугөлдэй’ /Ch’ongö Nogöltae/-аас гадна тухайн үед манж хэлний сурах бичиг, толь бичгийн зүйл нэлээдгүй олон байсан бөгөөд бидний үед уламлан ирсэн ‘Samyökh ch’onghae (三譯總解) /General Understanding of the Triple/, ‘Ch’ongö Nogöltae (清語老乞大) /Nogöltae of Manchu language/, ‘P’alse-a (八歲兒) /Eight-year-old Boy/, ‘Soa-ron (小兒論) /Discussions of the Child/’ зэрэг сурвалжууд буй.

⁷ Гуулин улсад 1393 оноос ‘Sayögwön’ (사역원) хэмээх орчуулагч бэлтгэх тусгай газар байгуулж Монгол, Хятад, Япон, Зөрчин хэлийг судалж сургаж байжээ.

⁸ 성백인(1999:130).

⁹ Нингүта- Манжийн хаадын холын төрөл буюу зургаан өвөг.

‘Чонг о нугелдэй’-г анх манж хэл рүү орчуулсан тухай ‘Шин сог Чонг о нугелдэй’¹⁰ –н оршилд: “...Манж хэл судлал нь эрт болоод эдүгээ үед бусад хэлний орчуулагч дундаас хамгийн их шаардлагатай байгаа бөгөөд сурахад хамгийн бэрх нь. Манж хэлээрх Нугелдэй, Сам ёг чунг хэ зэрэг сурах бичиг байгаа бөгөөд угаасаа өгүүлбэрийг орчуулж тулгаж хийсэн бөгөөд үүгээрээ хоорондоо төдий л их ялгаа байхгүй. Харин нугелдэй нь пёнжа(1636)-гаас эхлээд манай Дунг хуан жа (동환자) нар¹¹-ын хэлээр тайлбарласан зүйл юм. Бүр анхнаасаа тулгуур болгох буюу дууриан хийж болохуйц эх байхгүй байсан болохоор зөрүүтэй зүйлийг хянахад хэцүү байсан ...”¹² хэмээн дурдсан байдаг аж. Өдгөө ‘Чонг о нугелдэй’-н гурван хуулбар эх байгаа бөгөөд нэг нь Парисын Дорно дахины хэл судлалын сургуулийн номын санд хадгалагдаж байна. Энэхүү эхийг Солонгосын Ёнсэй их сургуулийн профессор Мин ЁнГюү(Min Yong-gyu) эхийг зургаар авч 1964 онд хэвлүүлсэн юм. Харин нөгөө нэг эх нь Лондонгийн Их Британийн музейд хадгалагдаж байгаа бөгөөд 1998 онд Сун Гижүн (Song Ki-jung) хэвлүүлсэн. Гурав дахи эх нь Японд байна. Бид тус илтгэлдээ ‘Чонг о нугелдэй’ /Ch’ongö Nogöltae/-д манж хэлний дуудлагыг хангыл үсгээр хэрхэн тэмдэглэсэн тухай авч үзэхийг зорилоо. Ингэхдээ эгшиг ба гийгүүлэгч үсгээр ялган зааглаж авч үзэх бөгөөд гадаад үг тэмдэглэх манж хэлний “*tulergi hergen*” үсгийн тухайд энэ удаагийн илтгэлд хамруулахгүй болно.

Манж хэлний эгшиг үсгийг хангыл үсгээр тэмдэглэсэн нь:

Манж хэлэнд [a, e, i, o, u, ü] гэх 6 богино эгшигийг үгийн эхэн дунд адагт орох байрлалаар өөр бичдэг.

Манж хэлний [a] эгшигийг¹³ солонгос хэлний [아] эгшгээр тэмдэглэжээ.

amba [암바](1:1a), adarame [아다라머](1:2a), antaka [안타카](1:10a)

Харин хамжин шүргэх [š, č, j, y] гийгүүлэгчийн ард орсон тохиолдолд солонгос хэлний [ㅇ] эгшгээр тэмдэглэжээ.

šanyan [상난](1:6a), yamji [얍지](1:13a), unčame[운차머](6:7a).

Хос эгшиг [ai]-г үгийн эхэнд, дунд, адагт аль ч тохиолдолд солонгос хэлний [애] -гээр тэмдэглэжээ.

aibe [애버](1:4a), saikan [새칸](4:3b), udhai [운해](7:8a)

